**МОНГОЛ УЛС**
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2021 оны 01 сарын 21 өдөр Дугаар А/35 Мандалговь

Газар эзэмшүүлэх хэмжээ өөрчлөх тухай

Монгол Улсын газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, 2013 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 21 дүгээр зүйлийн XX.1.43 дахь хэсэг, Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 21 дүгээр зүйлийн XX.1.43 дахь хэсэгт тусгагдсан "Газрын кадастрын мэдээллийн сан"-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд "Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх" ажил хэрэгжсэнтэй холбогдуулан хавсралтанд дурьдсан 1 байгууллагад 14925 м.кв (1,492 га) газрыг эзэмшүүлсүгэй.

Хоёр. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан хавсралтад заасан аймгийн Засаг даргын захирамжийн холбогдох хэсгийг мөн газар эзэмших гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гурав. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (С.Бат-Оргил), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Тербат) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

481219?74

Аймгийн Засаг даргын 2021 оны 01 дугаар сарын
21 өдрийн А/35 тоот захирамжийн 1 дүгээр хавсралт

| № | Эзэмшигчийн | | | Өмнөх | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Захирамжийн | | Газрын | | | | | |
| | Төрийн байгууллагын | Улсын бүртгэлийн дугаар | Регистрийн дугаар | Огноо дугаар | Холбогдох хэсгийн дугаар | Нэгж талбарын дугаар | Хэмжээ/ м2/ | Хэмжээ/ м2/ | Байршил | Ашиглалтын зориулалт | Эзэмшүүлэх хугацаа |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 7 | 8 | 9 | 11 | 12 | 13 | 14 |
| 1 | Дундговь аймгийн ерөнхий боловсролын Говийн ирээдүй цогцолбор сургууль | 868001101 | 9033769 | 2012.06.06.А /328 | 2012.06.06. А/328 1дэх хэсэг | 111600029 | 11336 | 14925 | Бага тойруу- 1-102 | Боловсролын зориулалтаар | 30 |
| | нийт | | | | | | 11336 | 14925 | | | |